

Таван зүйлийн тариаг хураах зан үйл, бэлгэдэл

Баттөмөрийн Хоролсүрэн 

Соёл урлагийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, ахисан түвшний хөтөлбөрийн алба
Улаанбаатар, Монгол Улс
✉ horloo.0216@gmail.com

Доржпаламын Мандах 

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Монголчууд идээ ундаагаа таван өнгөөр бэлгэддэг уламжлалт соёлтой ард түмэн. Үүнд, хөх, цагаан, улаан, хар, шар идээ тус бүр орно.

Уламжлалт газар тариалангийн, тэр тусмаа гар тариалангийн соёл нь хөх идээнд холбогдох бөгөөд таван зүйлийн тарианы үрлэлттэй холбоотой зан үйл, ургуулах үеийн гар ажиллагаа, “бүх” хэмээх усалгааны системтэй холбоотой зан үйл, бэлгэдэл зэргийг өмнө судалж, тодорхой үр дүнгүүдийг гаргаж хэлэлцүүлсэн болно. Биднээс өдрөөс өдөрт алсарч буй гар тариалангийн соёлын хамгийн чухал хэсэг тариа хураалтын үеийн зан үйл, бэлгэдлийн асуудлыг хээрийн судалгаагаар тусгайлан тодруулж буйгаараа энэхүү судалгаа онцлогтой.

Таван зүйлийн тарианы болц төрөл тус бүрд харилцан адилгүй хугацаанд боловсордог нь өндөр уулын, ойт хээр, нам доор газар, хур бороо, чийгшилт, хөрс, халуун хүйтнээс шалтгаалдаг. Гар тариаланг боловсруулж ашиглан өөрийн хүч хөдөлмөрөө зориулан баялгийг бүтээж буй тариаланчид өвлөн уламжлагчид юм.

Монголчуудын тариалангийн соёлд ажил хөдөлмөр, авьяас билгийн мэдрэмжээр аяндаа хэлэгдэж буй болсон аман соёлын илэрхийлэл, түүнийг буй болгосон хүчин зүйлүүд өөрийн биеэр үлгэрлэн, мэдлэг туршлага хуримтлуулсан тариаланчдын гар аргаар тариагаа хураах ардын мэдлэг ухаан хоёрын олон зуун жилийн хөдөлмөр хэрхэн яаж одоо цагт ч харилцан шүтэлцээтэйгээр уламжлан хөгжиж ирснийг өнөө үеийнхэнд сурталчлан таниулах, сурвалжлан тэмдэглэж авч үлдэх хэрэгцээ шаардлага байна. Үүнд эл судалгааны ач холбогдол, үнэ цэн оршино. Гар аргаар тариа хураах зан үйл, бэлгэдэл, аман яруу найргийг сурвалжлан цуглуулж, экологид ээлтэй уламжлалт монгол эрдэм ухааныг нэгтгэн судалснаараа энэхүү ажлын шинэлэг тал оршино.

Түлхүүр үгс: хөх идээ, аман соёл, уламжлал, хүн, байгаль

Rituals and Symbols for harvesting five species of crops

Khorolsuren Battumur ✉ 

Research and Advanced program department, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ horloo.0216@gmail.com

Mandakh Dorjpalam 

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Mongolians are a people with a traditional culture of five species of food and drink. We are studying one type of it, the “Blue Food” culture, based on the example of five species of crops. An important part of this traditional farming culture is the harvest season. The ripeness and quality of the five species of crops vary from place to place.

Each crop’s ripeness varies depending on factors such as the location of the crop field (high mountain region, forest fields, lowlands), rainfall, humidity, and air temperature. To study the rituals and symbols of a harvest, based on the example of five species of crops, it is necessary to study the following rituals and symbols related to the harvesting: Mongolian traditional food and drink culture, Clarifying the rituals of the “Blue Food” and five species of crops, Traditional hand farming methods of ethnic groups, Traditional agricultural irrigation system or “Bukh” culture, Rituals and symbols of planting seeds, Problems of disseminating traditional rituals of the “Blue Food”.

We will also interpret the symbols, rituals, and folklore culture used during harvest.

Keywords: *blue food, folklore culture, tradition, human, nature*

Оршил

Тариа хураах үеийн ёс заншил зан үйл, бэлгэдэл нь тариалангийн соёлыг бүрдүүлэгч нэг элемент юм. Монголчуудын аман болон биет өвийн шүтэлцээнд соёлын элементүүдийг нэгтгэн үзэж, тариа хураах зан үйл, багаж эд хэрэгсэл, арга технологитой нь уялдуулан авч үзнэ.

Монголчуудын тариа хураах талаар Ж.Бат-Ирээдүй, Ч.Арьяасүрэн нар “Монгол ёс заншлын их тайлбар толь”, дэд ботид Газар тариалангийн холбогдолтой ёс заншил хэмээх хэсэгт арвай тариалах торгууд заншил, монгол арвай, ургац хураах цагийн наадам зэргийг багтаан өгүүлсэн нь бий. Мөн судлаач Б.Роломжав тариа хураалтын үеийн ардын мэдлэг ухааныг бичсэн байх бөгөөд үүнд үндэслэн, хээрийн шинжилгээгээр тодруулан зан үйл, бэлгэдлийн үүднээс судлав.

Хөх идээний төрөл зүйл, таван зүйлийн тариаг монголчууд Хүрэл зэвсгийн үеэс өнгөлгөөт чулууны үед зэрлэг ургамлаас таримал болгон тариалж, хэрэглэж, хөгжүүлсээр ирсэн уламжлалт соёлын нэг болохыг археологич, түүхч Н.Сэр-Оджавын судалсан Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигт хаднаах анжис хөллөж үхэр хөтөлсөн хүү, анжсаа дарж газар хагалж буй эрэгтэй, тариа цацаж буй байдалтай хоёр эмэгтэйн зураг, мөн Булган аймгийн Орхон сумын Баруун могойн хаднаах зургуудаас харж болох юм. Эртний хятадын судар бичгүүдэд монголчуудын



*Зураг 1. Баянхонгор аймгийн
Бичигтийн хаднаах зураг
Эх сурвалж: ШУА.
Археологийн цуврал. IV
боть, 178 дахь тал. ШУА,
Археологийн хүрээлэн.*

тариалангийн тухай судлаач Б.Буянчуулганы судалснаар “Жи жы гэнъ тун цзянь ган мү жян бэнь бичиг”-ийн тэргүүн дэвтрийн 1.6 хуудсын ард таван зүйлийн үрийг тарьж боловсруулжээ. ... 5.81 ард, Хань улсын Юань-Кан-гийн хоёрдугаар (НТӨ 64) онд Хүннү улс, Чи жи улсад тариалан үйлдэх ардыг хөнөөх тул эгүүлж Чюй ли газарт суулгав. Хүннү улсын тэргүүлсэн сайдууд цөм Чи жи улсын газрыг өн сайн, Хань улс олж тариалан үйлдэж амуу үлэмж цуглуулбаас эрхгүй бидний улсыг сөнөөмүй. Тэмцэхгүй болбоос болохгүй хэмээн хэд хэдэн удаа цэрэг илгээж, Чи жи улсын тариалан үйлдэхүй ардыг дарсан хэмээжээ” (Буянчуулган 1937, 20, 21) гэсэн баримтаас үзэхэд, монгол нутагт эртний улсуудын үед тариа тарьж байсан бөгөөд хүннүгийн хөгжүүлсэн тариан талбайг Хань улсын түшмэд хэлэлцэн сүйтгэдэг байсныг “удаа дараа цэрэглэн” гэсэн үгээс харж болно. Учир нь амуу их тариалаад хүчирхэг болбол, Хань улс руу дайтаж, тэднийг сөнөөнө хэмээн тариачин ардыг дардаг байсныг бичиж үлдээжээ. Үүнтэй уялдуулан монгол нутагт тариалан эрхэлсэн эртний үеэс өнөөг хүртэл гар аргаар тариалж ирсэн соёлын уламжлал байх ба

тариа хураалттай холбоотой зан үйл, бэлгэдлийг судлан цуглуулж нэгтгэн авч үзэх явдал чухал. Dorian Q. Fuller “Pathways to Asian Civilizations: Tracing the Origins and Spread of Rice and Rice Cultures” (Дориан К.Фуллер “Азийн соёл иргэншилд хүрэх зам: Будаа, будааны соёлын гарал үүсэл, тархалтыг судлах”) судалгааны зургийг ажиглан харвал, хэрэглэх багаж эд хэрэгсэл нь өөр боловч монголчуудын тариа хураах үйл явцтай тохирч байгаа юм.

Судалгааны арга зүй

Хөх идээний соёлд хамаарах салшгүй нэгэн хэсэг тариа хураах зан үйл, бэлгэдэл, нутгийн аялгууны үг зэргийг хээрийн шинжилгээний явцад ярилцлагын арга, оролцон ажиглах, аман сурвалжийн мэдээлэл цуглуулах болон шинжлэх ухааны түгээмэл арга зүй бэлгэдэл зүй, герменевтик, харьцуулалтын арга зэргийг ашиглав.

Судалгааны үр дүн


Соёл судлалын ухааны хэрэглээний соёлын хүрээнд хөх идээний нэг төрөл, таван зүйлийн тарианы зан үйл бэлгэдлийн судалгааны дотор тариа хураах зан үйл бэлгэдлийг өндөр уулын бүсэд хийсэн хээрийн шинжилгээнд тулгуурлана. “Соёл” гэдэг үг нь салаа утгаараа “аж ахуй” гэсэн үгтэй утга нэг бөгөөд эхэн үедээ оюун санааны соёл, бурхны шүтлэг, өвөг дээдсээ хүндлэх зэрэг ямар нэг юмны соёлыг илэрхийлж байв. Эртний Римийн төрийн зүтгэлтэн, зохиолч Марк Порций Катонийн бичсэн газар боловсруулах тухай тайлбарыг латинаас орчуулбал “газар

тариалангийн соёл” гэсэн утгатай ойлголт гарч ирдэг.. дараа нь хэрхэн арчлан хамгаалах асуудал гарч ирж байгаа юм. ...Соёл гэсэн ойлголт “окультизм” буюу байгалийн далдын хүчийг шүтэх үзэлтэй нэлээд ойролцоо (Гуревич 2012, 62) гэснээс үзэхэд, хүн төрөлхтний соёлын анхдагч үзэл газар тариалантай холбоотойгоор бий болсон бөгөөд үүнийг бэлгэдэл зүйтэй холбон тайлбарлаж байжээ. Монголчуудын хөх идээний соёл ч бас үүнтэй холбоотой.

Rice (2011) 4:78–92

81

Fig. 3 Contrasting the feedback loops of the proto-*indica* hypothesis (bottom) and the *japonica* domestication pathway (left). This has been added to a diagram contrasting wild versus domesticated crop processing (Fuller et al. 2010b).



Зураг 2. Азид тариа боловсруулах болон үр тарианы төрөл зүйл, тархац
Эх сурвалж: Dorian Q. Fuller “Pathways to Asian Civilizations: Tracing the Origins and Spread of Rice and Rice Cultures” DOI 10.1007/s12284-011-9078-7

“Монголчууд тэнгэр шүтлэгтэй ард түмэн. Ерөөл, магтаал, цацал мялаалга, тахилгын болон бэлгэ дэмбэрлийн үгэндээ “Эцэг болсон хөх тэнгэр, Эх болсон газар нутгаа” магтан алдаршуулж эх дэлхий, төрсөн газар нутгаа хайрлан хамгаалдаг биет бус соёлын өвийн бүхэл бүтэн тогтолцоотой...” (Уртнасан 2010, 9) байгаль экологид ээлтэй, газар нутгаа хайрлаж, үр шимийг нь хүртдэг билээ.

Хүн судлалын эрдэмтдийн үзэж буйгаар “...экологийн антропологи нь хүмүүний амьдрал болон хүрээлэн буй орчин хоорондын харилцаа холбоо, шүтэлцээг цаг хугацаа, орон зайн хувьд судалдаг. Энгийнээр бол аливаа нэгэн соёл болон хүрээлэн буй орчин хоёрын хоорондох бие биедээ нөлөөлж байдаг тэр харилцааг судална гэсэн үг юм (Мөнх-Эрдэнэ, Чулуунбат 2017, 221) гэснээс үзэхэд, бидний судлагдахуун тариа хураах зан үйл байгаль орчинд ээлтэй байдлаар хөгжиж иржээ. Мөн тухайн газар нутагт, тухайн цагт амьдарч байсан хүмүүний экологи, газар зүйн уламжлалт монгол мэдлэгийн үр дүнд өнөөдөр ч давтагдашгүй орчин, соёлыг бүтээсээр иржээ. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Шарга сумын Урд голын жимс жимсгэнэ бүхий тариан талбайг улиас, бургас тойруулан тарьж салхи, элснээс хамгаалсан нь говийн нөхцөлд экологийн өвөрмөц таатай орчныг бүрдүүлэн сонирхолтой бүс болгожээ.

Тариа хураах үйл явц *экологийн антропологийн* хувьд хамгийн энгийн бөгөөд үр дүнтэй тогтонги шинжтэй соёл юм. Судалгаанаас үзэхэд, Говь-Алтай аймгийн Шарга, Бигэр, Ховд аймгийн Булган, Увс аймгийн Тариалан сумын ардууд эртнээс зургаадай арвай, хөх арвайг дээдэлж, гар аргаар газар бүрд харилцан адилгүй нөхцөлд тариалж иржээ. Үр тариа ургуулах уламжлалт соёлын голомтуудад дараах газрууд зүй ёсоор багтана.

Говь-Алтай аймгийн Шарга сум: Чулуурхаг, элсэрхэг, давсархаг, шар шороон хөрстэй. Үүнд:

- Тэгшийн тариалангийн талбай
- Хотгор цагааны тариан талбай
- Модон гэрийн
- Баруун дөрөвтийн голын
- Дунд шарын голын
- Харганатын амны
- Ээвийн голын
- Гүжгэнийн тариан талбай гэх мэт.

Говь-Алтайн Бигэр суманд: Бор гол, Өөш, Хоёр байшинт, Бургас, Мянгай, Бор газар зэрэг голомтууд байна.

Хотон угсаатны тариалангийн гол бүс *Увс аймгийн Тариалан* сум өндөр уулын бүсэд оршдог. Арван гурван хан Алтайн Хархираа Түргэний уулсаас эх авсан ширүүн урсгалт Хархираа, Түргэний голын үржил шимт зөөлөн шар шороон хөрстэй.

Торгууд угсаатны нутаг Ховд аймгийн Булган сумын хөрс нь үржил шимт цайвар шороон хөрстэй, Баян-Өлгий аймгийн Булган сумын Булган багийн Холбоо нуураас эх авсан Булган голын сав газарт, Алтайн нурууны салбар уул Сутай хайрханы өмнөд сугаас урагш байрласан, өндөр уулын бүсэд оршдог. Эдгээр гар тариалангийн соёлын голомтуудад тариа хураалт ижил үед өөр өөрийн онцлогтой явагдана.

Уламжлалт газар тариаланд талбайг ээлж дараалан өнжүүлж тариалдаг бөгөөд 2-3 жил өнжсөн шим тэжээл нь бүрдсэн газрыг ахмад тариаланчид үзэж мэдээд **газар таргалсан** байна, энэ жил тэр талбайд тариа тарина хэмээн шийд гаргадаг аж.

Анх тариалснаас хойш арвай 45-50, буудай 75-80 хоногт боловсорч гүйцнэ (Гонгоржав 2008, 355).

Ургац хураах үе шат: Тариан түрүү шаргалтсан үеэс тариагаа хураах болжээ гэж үздэг. Ингээд тариагаа цайруулах том цан бэлтгэнэ. Энэ нь тариа хураахаас 14-21 хоногийн өмнө хийгдэнэ. Гэрийн буурин чинээ газрыг зуун лангийн ембүүг цуулаад наачихсан мэт тэмээний тавхайгаар гишгүүлж, газрыг тагтшуулан, нарны илчинд хатууруулж бэлтгэнэ (Говь-Алтайн Бигэр, Шарга сум). Харин Хотонгууд тариагаа хураахдаа таригийнхаа хажууд хүрзээ дээш нь харуулж тавиад ном уншдаг.



Зураг 3. Цан буюу харам бэлтгэх үйл явц

Энэ нь тариа хураахад зориулж уншдаг ном юм. Харам¹ гэдэг нь тариагаа хурааж авч цайруулдаг газар. Ширгийг нь хусаж, чулууг авч ус цацаж дош болгоно. Ховд аймгийн Булган сумын тариаланчид тариагаа хураахдаа талбайдаа мөн л өдрийн сайныг харж ирэх ба арцаа уугиулж, *Баян Алтай хишгээ хайрлаа* хэмээн сүү, идээ будааныхаа дээжийг өргөж тариагаа хурааж эхэлдэг.

Тариан толгой хэсгийг гар хадуураар хадна. Энэ үед хүн ирвэл, *Хадуур мох* (Говь-Алтай, Шарга сум), *Ургац өндөр, хадуур хурц байг ээ* (Говь-Алтай, Бигэр) гэсэн бэлгэ дэмбэрлийн үг хэлнэ. Тариа хадаж буй хүн *Ерөөл оршиг ээ* гэж бэлгэшээж баясацгаана. *Хадуур мохог* гэсэн энэхүү бэлгэ дэмбэрлийн үг нь хадаж буй хадуураа мохтол арвин их тариа хураахыг бэлгэдсэн шинжтэй. Торгуудууд тариа хурааж буй үед таарвал, *Ургац чинь арвин болтугай* гэж ерөөдөг. Газар газрын бэлгэ дэмбэрлийн үг өөр байгаа боловч утга санаа нь ижил, арвин ургац авахыг ерөөн бэлгэдэж байдаг. Тариагаа хадаж хэд хоног хураагаад тавихад түүхий ногоон тариан түрүүний болц нь гүйцэж шаргалтаж эхэлнэ. Үүнийг тариаланчид гүйцэд болсон тарианы дундах илчинд нь дутуу болц гүйцдэг гэж үздэг.



Зураг 4. Эх сурвалж: Сэтгэлд ургасан арвай. Баримтат киноноос. Мориор тариа гишгүүлж, цайруулж буй нь

Дараа нь цан дээр тариа цайруулах ажил хийгдэнэ. Хадсан тариагаа бооц² бооцоор тэрэмлэж³ давхарлаж тавина. Бэлдсэн цангийнхаа дунд хүйс⁴ ургуулна. Хүйсээ тойруулаад морь хөллөнө. Хэрэв үр авах тариа бол шар хөллөнө. Хүнсэнд хэрэглэх тариа цайруулахдаа морь хөллөнө. Тариа нь доош унаад сам нь үлдээд, самыг нь аваад хажуу тийш нь ялгаж тавиад явдаг. Малынхаа хөлөөр том хэсэг нь гадагшаа гарна (Төвөөс зугтах хүчний үйлчлэлийг хэрэглэдэг байна). Энэ үед гаднаас хүн ирвэл, *Харам нь*

дүүртүгэй (хотонгууд) гэнэ. Говь-Алтайхан *Цан халиг* гэж бэлгэшээдэг байна. Энэ нь цайруулж буй тариа нь харамаа давж арвин байх болтугай, цангаа хальтал их тариа авах болтугай хэмээх бэлгэдэлт утгатай.

Увсын Тариалангийнхан:

Гантай үед ч тариа алдаж байсан түүх байхгүй

Гантай хатитай хахир жилдээ ч

Ганхсан тариа хурааж авдаг

Галдан бошготын удмынхан гэж ярьдаг (Цолмон 2020).

“... Намрын сарын адаг, өвлийн эхэн сард тариагаа цайруулахаар гишгүүлэхэд үхрээ тав таваар хүзүүгээр нь холбож зулсан тариан дээгүүрээ эргэлдүүлж хэдэн хүн хөтөлж, хүүхдүүд туудаг ба тариаг ийнхүү гишгүүлэх үед:

¹ Харам-тариа цайруулах зориулалт бүхий, тагтшуулж толийлгосон талбай

² Бооц- багцалж, тэвэр болгон боосон тариан түрүү

³ Тэрэмлэх-тариагаа ханалж давхарлаж тавих

⁴ Хүйс-харамны төвд морь, шар уяж эргүүлэх зориулалт бүхий шон

Цацаг молцог түрүүтэй

Тариан бооз нуруутай

Эргэн тойрон үтрэм дээр

Гий хийг гий хийг гэх мэтээр аялах ба үүнийг “Гишгүүрийн дуу” гэж зарим газар нэрлэдэг” (Уртнасан 2010, 227).



Зураг 5. “Сэтгэлд ургасан арвай”
баримтат киноноос. Тариа нөөцөлж
өвөлжүүлэх уурхай хэмээх зоорь

үед хөлд хамгийн ойр унаснаас нь хүнд жинтэй чанарлаг хөрөнгө тариа, өөрсдөө идэх, бусдад өгөх, худалдах гэх мэтээр ангилдаг.

Тариагаа хурааж дуусаад дараа хавар хүртэл үрээ нөөцлөх уурхайг⁹ бэлтгэдэг. Хааш хаашаа ижил хэмжээтэй дөрвөлжин нүх ухаж, хуурай шаваг шатааж доторлодог. Энэ нь уурхайгаа хуурай байлгах, үр шатахаас хамгаалсан технологи юм. Үр нойтон байвал соёолох, шатах зэрэг эрсдэлтэй. Уурхайд үрээ хийж сүрлээр, дараа нь шороогоор хучиж өвөлжүүлдэг. Энэ шоо дөрвөлжин уурхайд 580-700 кг арвай нөөцөлдөг. Үүнийг цангийнхаа хажууд хийдэг бөгөөд уурхайнуудаа сахиж нэг айл өвөлждөг. Өвөл уурхайгаас тариа авахдаа сахиул хүнд нэг суулга¹⁰ тариа өгнө гэх мэт ирсэн айл бүр манаачийн хөлс өгнө. Мөн тариагаа нөөцлөх ханз гэдэг нэртэй зоорийг шатаасан тоосгоор хийдэг байжээ.

Тариагаа хурааж дуусаад айл хотлоороо баяр хийнэ. Энэ нь өндөр Алтай, уул хангадаа цай сүүнийхээ дээжийг өргөж, их тариа өгсний баяр, их ажлын ард гарсны баяр, ургацын баяр. Алтайнхан морь уралдуулж баярладаг бол торгуудууд цагаан мод хаяж тоглодог байна. Энэ нь байгаль дэлхийгээ баясгаж, хүн ардынхаа эрүүл энх, амгалан байхад сэтгэлийн их цэнгэл эдлүүлж, ирээдүйд урам зориг хайрласан баяр болдог байна. Ургацын баярын түрүүлсэн морьд, эздэд нь суулга тариагаар хэвсэн өгч, *Энэ тариагаа арвижуулж аваарай* гэж ерөөдөг байна. Ер нь тариаланчид тариа хураалтын үеэр ирсэн хэнд ч хэвсэн буюу ажлынхаа дээжээс

⁵ Башиг - Мажтан овгийн, уулын хажуу, гол горхины хөвөөгөөр ургадаг нэг наст ургамал, иш нь дөрвөн ирмэгтэй, шулуун ургана, навч нь далавч бүхий бариултай, чагтлан ургана: гоё башиг [ургамал] (хөхөвтөр цэцэгтэй, жижиг хатуу жимстэй нэгэн зүйлийн өвс)

⁶ Ашин - талбай дээр хаягдаж үлдсэн тариан толгой

⁷ Лайтай тариа - шороо, сүрэл зэрэг хогтой тариаг хэлнэ.

⁸ Саван - түрүүг нь авсан тарианы иш буюу сүрэл, малын тэжээлийг хэлнэ.)

⁹ Уурхай - тариа нөөцлөхөөр газар ухсан нүхэн зоорь

¹⁰ Суулга - 5-7 кг тариа багтах модон сав

хувь түгээдэг нь тариа будааны боловсруулалт, ажлынхаа шимээс амсуулах, ажил үйлс арван зүгтээ арвижин дэлгэрч, будаа шиг өсөж, өөдөлж явахын өлзийтэй ерөөл өргөж байна гэсэн утгатай юм. Ургацын баяраар үтрэмийн ерөөл хэлдэг.

Таван тарианы үрийг
Тансаг элбэг хураалгасан
Төвшин талбиун үтрэмээ
Тараг айргаар мялаамуу
Бумбар бумбар гүйсээр
Бум түмээр яндуулсан
Бул цагаан өвгөнөө
Боов амсаар мялаамуу
Хүчээ өгсөн хүрз
Ачаа өгсөн ац
Шимээ өгсөн шүүрт хүртэл



Зураг 6. Торгуудын ургацын баяр. Торгууд, их шарнууд овогт И.Оюунбилэгийн авсан зураг. 2023.10.15

Шүүсний дээжээр мялаамуу (Гантогтох, Батсүх 2015, 196) гэж үтрэм, ажлын багаж хэрэгсэл тус бүрийг ерөөн магтаж байгаа нь сонирхолтой. Үүнээс үзэхэд, аман яруу найргийн орчин үеийн үүрэг зориулалт буураагүй байгаа нь харагдана. Тариа хурааж дуусаад газраа бордсоны дараа тагтаа усаар дүүргэж, цэнэг усалгаа хийдэг. Цэнэг усалгаа дууссаны дараа ус хөлдөж, ургамлын үндэснүүд усны мандалд гарч ирнэ. Энэ нь дараа жилийн тариалангийн талбайд хог ургамал ургахгүй байх бэлтгэл ажил болдог.

Хагалж, тээвэрлэх, нөөцлөх зэрэг бүхий л үйл ажиллагааг техник оролцуулалгүй гар аргаар боловсруулж, байгальд ээлтэй, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд уламжлалт тариалан эрхлэгчдийн уйгагүй хөдөлмөр чухал ач холбогдолтой байдаг. Говь-Алтай аймгийн аварга тариаланч Д.Нямжав гуай “Нэг талбайгаас комбайнаар хадсан, гараар хадсан хоёрын арвайн гурил өөр амттай байдаг. Комбайнаар хадсан гурил амт муутай байдаг...” гэж ярьсан нь уламжлалт гар аргаар тариалж хураасан арвайн болц, шим тэжээлд нөлөөлдөг зэрэг эрчим ч юм уу ямар нэг аятай нөлөө байдаг бололтой.

Тариалангийн өдөр тутмын үйл ажиллагааг соёл гэж ойлгодог тариаланчид бий. “Арвай тарьж, үйлдвэрлэж, хэрэглэж байгаа, нэгэндээ арвай өгч байгаа энэ бүгдийг урлагаар илэрхийлж байдаг. Тариа бол түүх. Урлагаар хөөхөөр соёл, соёлоор хөөхөөр биелгээндээ, дуундаа, ерөөл магтаалдаа, хийж байгаа ажил зан үйлдээ оруулчихсан байгаа шүү дээ” (Цолмон 2020) хэмээн тариа тарих зан үйл урлаг, соёл юм гэх ойлголтоо тайлбарлаж байв.

Газар тариалангаас үүдсэн биелгээ: Усанд явж байсан ах дүү хоёр залуу, модны хаяанд суугаад харж байтал модны найгах хөдөлгөөнийг ажиглаж, тариан түрүү найгаж байгаатай ижил байна гэж ярилцаад босож биелсэн гэдэг. Ац биелгээг эндээс үүсэлтэй гэлцдэг. Дүү нь ахыгаа хөлөөрөө хавчиж салхины аясаар найгаж байгаа тариан түрүүг дүрслэн намирч, бие нь газарт шүргэж гурав өндийгөөд биелдэг. Сэдэн залуу¹¹ гэдэг биелгээнд тариагаа цацаж тарьж буй, газар хагалж, хурааж, цогнож, үрээ амандаа хийн идэж, тээрэмдэж, баясан цэнгэж буй тариалангийн

¹¹ Сэдэн залуу-Хотонгуудын ярьснаар бүх юмыг хийж чаддаг сэргэлэн залуу гэсэн үг.

зан үйлийг харуулсан дүрслэлтэй байдаг. Сэдэн залуу биелгээний үүслийн талаар Зинаметр гуайн яриа бий. Нэгэн сайхан залуу байжээ. Тэдний хошуунд нэгэн сайхан охинтой баян айл байж. Сэдэн залуу тэр охинтой яаж уулзах вэ гэж бодож явсаар байтал, ноёны хүү түүнийг гэргий болгох сураг гарчээ. Нэг өдөр залуу гэрт нь орвол охин үйл мэтгээд сууна гэнэ. Ярих эвээ олохгүй байж байгаад,

Сэдэн залуу цайгий нь мэнд орж ирлээ

Сэвгэр охин үйл оёод сууж байна гэж магтаж, тэгэхэд охин хариу хэлэхэд, сэдэн залуу:

Сэдэн залуу цайгий нь

Сэвгэр охин үйлий нь гэж хэлээд хуурыг нь аваад татлага татаж, биелгээ хийж танилцжээ. Ингээд сэдэн залуу гэдэг биелгээ үүссэн гэнэ (Соёлын өвийн үндэсний төв. DV copy II (Bet-26) 12 тоот)

Мөн торгуудуудын дунд тариатай холбоотой эртнээс яригдаж ирсэн домог байдаг. Ховог сайраас цааш Харнай хот явах замд Хош толгой гэдэг газар байдаг. Эл газрын домог нь:

Нэг тариачин залуу тариа тариад тэр жил тариа нь маш сайхан ургаж. Тариагаа хурааж хоёр талдаа овоолоод сууж байхад нь нэг ядарсан өвгөн иржээ. Миний хөвүүн тариа нь сайхан ургав уу. Залуу: Сайхан ургалаа. Өвгөн: Тарианаасаа жаахныг өгөөч гэж гуйж гэнэ. Гэтэл тариачин эр: Чам шиг хүнд тариа өгөхгүй ээ гэж. Тэгтэл ядарсан өвгөн: Баян Алтай чамд тариа өгөв үү? Чи эр сайндаа тариа хурааж авав уу? гэж асуужээ. Тариачин эр: Би чадалтай эр сайндаа тариа хурааж авлаа гэж гэнэ. Гэтэл өвгөн: Баян Алтай чамд хишгээ хайрлаагүй бол чи юундаа тариа хурааж авах вэ? тарьж хураасан тариа нь довон уул болог ээ гэж хэлээд явчихжээ. Тэгтэл хоёр хэсэг хураасан тариа нь хос шороон дов болоод тогтчихжээ. Тэр үеэс хойш Хош толгой буюу довон уул гэж нэрлэх болсон гэдэг. Энэхүү домогт Баян Алтай, байгаль дэлхийн хишиг буяныг ялгалгүй хүртэх, эр биед эрдэх бус өвгөд хөгшдийг ивээж яв! гэсэн санааг харуулсан байх юм. Үүнд хангай дэлхийгээс баян хүн үгүй бөгөөд “Баян Алтай” баялгаа хайрладаг гэсэн бэлгэдэлт санаа агуулагдаж байна. Өнөөх ядарсан өвгөн Баян Алтайн эзэн савдаг байсан бөгөөд ядуу гэж үзсэн залуугийн занг таньж, будаа тариаг нь уул болгон хувиргасан. Нөгөө нэг санаа нь элбэг дэлбэг тариа хурааж авсан бол олон түмэнд заавал хишиг хүртээж байх нь зөв гэсэн хамтач үзлийг шингээжээ (Хоролсүрэн 2023).

Газар усны нэршилтэй холбоотой уг домог тариаланчдын зан үйл, зан суртахууны төлөвшил, байгаль эх дэлхийгээ хайрлах, дээдлэх үзэл хүмүүний амьдралын сайн сайхан байх зөвхөн хүнээс шалтгаалахгүй, олон хүчин зүйл нөлөөлж байдаг гэдгийг илэрхийлсэн утга санааг тусгажээ. Мөн бусад будаа тарианд зориулсан аман яруу найргууд бий.

Сагаг гурван талтай

Санаа арван талтай

Сайн хүн үг даадаг

Сагагийн гурил ус даадаг

Сайн унаа нь саарал илжиг

Сайн хоол нь сагагийн гурил гэсэн зүйр цэцэн үг нь сагагийн гурилыг сайн юм бүхэнтэй зүйрлэсэн утгатай, шинж чанарыг нь дөвийлгөсөн шинжтэй байна.

Нанги будааны магтаал

Өвөг дээдсийн үеэс
Үлгэр түүхэнд дурсгалтай
Үрлэж тарьсаар ирсэн
Өнгө өнгийн нанги минь
Цагаан голын хөвөөн дээр
Цайрч ургасан цагаан нанги
Шар мөрний дэнж дээр
Шарлатал ургасан шар нанги
Зээ! Ямар нанги нь боллоо гээд

Ямагт сайхан амттай
Янз зүйг тааруулж
Ялгаж салган идэлтэй
Нарийлаг сайхан цайлгаад
Найрын будаа агшаадаг
Нягт талхалж индээд
Нангийн гурил болгодог
Ааг хальсыг нь эсгээд
Архи дарс нэрдэг.

Шүлхэй амууны магтаал

Нарьдын голын хөвөөн дээр
Найган ургасан шүлхэй амуу
Найман зуун хадуураар
Хадаад авсан шүлхэй амуу
Арал ихтэй тэргээр
Тээгээд авсан шүлхэй амуу
Ам цагаан үхрээр
Гишгүүлээд авсан шүлхэй амуу
Ин дээр нь хийхэд
Ивсэж байсан шүлхэй амуу
Ерэн найман илжигийг

Ергүүлж байдаг шүлхэй амуу
Адар¹² дээр тавихад
Авалцаж байсан шүлхэй амуу
Аяган дотор хийхэд
Цавуудаж байсан шүлхэй амуу
Чавганц ээж идэхэд
Цавуу адил наалдаад
Цангаалдаж байдаг шүлхэй амуу
(Гантогтох, Батсүх 2015, 192, 193)
гэх мэтээр магтан шүлэглэсэн байдаг.



Зураг 7. Нанги буюу шүлхий амуу, өөр нэр нь хоног будаа

Энэхүү будааг “...XVII зууны дунд үед монгол газраар зорчсон хятад жуулчин Сяо-да-хэний дурдатгалд, монголчуудын тарьдаг үр тариа нь буудай, нарим, буурцаг, шүлхэй амуу амой. Эдгээрийн уламжлан ирсэн нь уджухуй. Орчин үед эхэлсэн бус болой хэмээн бичиж тэмдэглэсэн шүлхий болон нарим хэмээгдэх хоног будаа өдгөө өвөрлөгч нутагт илүү өргөн таригдан уламжлагджээ. Шүлхийг бас нанги монгол амуу гэнэ. Монголчууд эртнээс энэ хоёр үр тариаг олон янзаар боловсруулж хоол хүнсэндээ хэрэглэж иржээ...” (Гонгоржав 2008, 711). Монголчуудын хоол хүнсний соёл, хэрэглээнд эдгээр будаа чухал үүрэгтэй байсан бөгөөд гадаадын эрдэмтэд судалгаа хийж, “...Монголчууд олон төрлийн хүнс тэжээлийг өргөн ашигладаг, бүр эртнээсээ л хоол хүнсний өндөр соёлтой байсан бололтой, хүнсний нөөцлөлтөд өндөр ач холбогдол өгч ...тухайн цаг үеийн дэлхийн өнцөг булан бүрд өлсгөлөн, хомсдолд улс гүрнүүд нэрвэгдэж байхад харин ч монголчууд

¹² Бургасаар гөрж сүлжин хийсэн цагаан шар усыг шүүрүүлэх зориулалт бүхий сарзгар тавиур дэлгэц



Зураг 8. Нарим будаа

хүнсний нөөцлөлт сайтай, илүүдэлтэй байсан нь Монголын эзэнт гүрнийг нутаг дэвсгэрээ тэлж, хүн амаа нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд дэлхийн талыг эзлэхэд энэ нь түлхэц өгсөн” (Shevan Wilkin, Alicia Ventresca Miller ба бус. 2020) гэж дүгнэсэн байдаг. Тэгвэл үүний баталгаа нь XIII зууны үед Монголын эзэнт гүрэнд худалдааны ажлаар ирж, Хубилай хаанд зарагдаж байсан Венецийн худалдаачин Марко

Поло “Орчлонгийн элдэв сонин” номд тэмдэглэснээс тодорхой харагдана. Үүнд:

... Их хаан тариа будаа элбэг дэлбэг хямд байх үеийг мэдмэгц түүнийг маш арвин ихээр худалдан авч тарианы их санд хураан гурав дөрвөн жил ялзарч муутгахгүй байлгахын тул сайхан хадгалж хайрлан хамгаалахыг зарлиг болгодог байжээ. Камбалу (Канбалык) хотын ядууст өглөг шан хайрладаг ... Их хаан улаан буудай, арвай, амуу тариа, тутарга, хар тариа зэрэг янз бүрийн тариа будааг нэн их хураах бөгөөд үр тариа хомсдох буюу үнэ өртөг ихсэхийн цагт тэр хураасан тариа будаагаа доорх маягаар ард олондоо түгээдэг байв. Хэрэв нэг хэмжүүр (нэг сав) улаан буудайг нэг безантаар худалдаж байвал их хаан нэг безантад дөрвөн хэмжүүрийг өгнө. Тариа будаагаа элбэг дэлбэг гаргаж хүн бүрд түгээх ба ханатал түгээнэ. Тийнхүү их хаан ард түмнээ будаа тарианд их сүйтгэл гаргуулахгүйн төлөө халамжлан санаа тавьдаг байжээ. ... Их хаан нийслэл хотын амин зуулга юу ч үгүй ядуу айл өрхийг цуглуулах зарлиг буулгадаг байжээ. Зарим айл найман ам бүлтэй, зарим нь арав, түүнээс их буюу цөөн, янз бүр байна. Хаан тэднийг хооллохын тулд улаан буудай болон бусад элдэв үр тариа түгээж цайлгахыг тушаадаг байв. Чингэхдээ хангалттай хүртээдэг байжээ. Бас нэгэн зүйлийг нэмэн хэлэхэд тариа төмс авахаар хааны ордонд хэн ч бараалхан ирсэн түүнд татгалзах явдал огт үгүй. Тариа будаагүй хэн боловч цөм хувь хүртэнэ. Өдөр бүр гурван түм гаруй хүн тариа будаа авахаар ирдэг байсан бөгөөд ийнхүү жил болгон их өглөг өгдөг байжээ (Марко Поло 1987, 120) гэжээ.

Хубилай хаан ард олноо ивээн тэтгэж өөрсдөөр нь тарианы ажил хийлгэж, тариа будаагаар хангаж байсан үед ард олон нь тариа будааны хангалттай нөөцтэй, хааны сан илүүдэлтэй байсан нь дэлхийг тохинуулахад түлхэц өгсөн байх нь ойлгомжтой. Ард иргэд нь Хубилай хааныг бурхан мэт шүтдэг байсан гэжээ. Зохиогч Хубилай хааны улс агуу баян тансаг байсныг бахдан бичсэн байдаг. Үүнээс, монголчуудын дундад эртний түүхэнд тариалангийн ажлууд газар боловсруулах, тарих, ургац хураах, хадгалах нөөцлөх зэргийг төрөөс нэгдсэн удирдлагаар хангаж, ард олноо өргөн асарч нийгэмд үзүүлэх үйлчилгээ дээд хэмжээнд зохион байгуулагддаг байсныг тодорхой харж болохоор байна.

Хэлэлцүүлэг

Тариа хураалтын уламжлалт зан үйл мартагдах шинжтэй, удмын бус, хожуу тариалан эрхэлсэн, техник технологийн хүчинд дулдуйдсан тариаланчид олширч, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран, ашиг орлогодоо анхаарсан арилжааны бүлгүүд орон нутагт төлөвшиж, үйлдвэрлэлийн харилцаа хөгжиж

байгаа нь ажиглагдлаа. Тариа хураах үеийн зан үйл нь үр суулгах соёлтой нягт холбоотой бөгөөд услах таван үе шатыг хугацаанд нь чанартай хийснээр арвай будаа хугацаандаа боловсорч хураан авахад бэлэн болдог, бие биеэсээ нөхцөлдсөн залгамж холбоотой үйл явц юм. Гар аргаар тариа хураах үйл явц нь эртнээс өвлөгдөн ирсэн уламжлалт соёл юм.

Дүгнэлт

Тариа хураах үйл явцад цан бэлтгэх, хадах, хатаах, цайруулах, нөөцлөх, малын тэжээл бэлтгэх, бордох (талбайд малаа оруулах), цэнэг усалгаа хийх зэрэг үе шатууд байх бөгөөд байгальд ээлтэй, эко системд хор уршиг учруулахгүйгээр зохион байгуулагдсан байдгаараа онцлогтой.

Ургац хураах үед тариачид, нутгийн хүмүүс бие биедээ урам, хүч чадал өгөх, сэтгэл санаагаар дэмжих зорилгоор бэлгэ дэмбэрлийн үгс, ерөөл, магтаал хэлж, аман яруу найргийн соёлыг хөгжүүлсээр ирсэн байна. Тариа хурааж байгаа хүмүүс дээр очихдоо тухайн ажилд заавал оролцож, гар хөдөлгөж тусалдаг заншилтай юм. Нутгийн ардууд өөрийнхөө гар хадуураар тариа хадах, мал, шувуу үргээх, исгэрч салхи гаргах, шигших, зөөх, уурхайд нөөцлөх, тээвэрлэх зэрэг ажилд оролцдог сайхан уламжлал хадгалагдан үлджээ. Орчин үед ихэнх тариалангийн газрууд комбайнаар ургац хураадаг болсон. Ховдын Булган сумын хөдөө аж ахуйн газар хоёр жилийн өмнөөс тариаланчдад комбайн өгч, ажил хөнгөвчлөх, хугацаа алдахгүй, хурдан шуурхай ургац хураалт хийхэд тусалжээ. Гэвч талбайд тариан түрүү их хэмжээгээр үлджээ, дахин гараар түүх ажлууд хийгдэж байна.

Монголчуудын тариалангийн соёлд ажил хөдөлмөр, авьяас билгийн мэдрэмжээр буй болгосон аман соёлын илэрхийллийг бэлгэ дэмбэрлийн үг, цацал мялаалгын үгс, ерөөл, магтаал, домог зэргээр хураах үйл явцтай уялдуулан тодруулан нэгтгэж харууллаа. Тариалангийн соёлд аман яруу найргийг бий болгосон субъектив хүчин зүйл нь тариаланчид өөрсдөө бөгөөд байгалийн далд хүчинд итгэн газар нутгаа хүншүүлэн дээдэлж зүй зохистой харьцаж иржээ. Гар аргаар тариалсан газар хэдэн жилийн дотор эдгэрэн атаршиж өмнөх байдалдаа ордог нь өнөө үед тун ховор үзэгдэл.

Техник технологийн хурдацтай хөгжлийн өнөө үед тариалангийн соёл гээгдэх шинжтэй болж байгааг судлан, соёлын өвийн чухал хэсэг тариа хураалттай холбогдох зан заншил, зан үйлүүдийг бэлгэдэл, аман яруу найргийн хамтаар сурвалжлан цуглуулж, байгальд ээлтэй монгол эрдэм ухааны цогц үйл ажиллагаа буйг тодрууллаа. Цаашид энэхүү соёлыг хадгалан үлдэх, бусад холбогдох зан үйлүүдийг тодруулах, эрэн сурвалжлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зэрэг ажлуудыг хийх, судлах шаардлагатай байгаа нь хээрийн шинжилгээгээр харагдаж байна. Үүнд орон нутгийн соёлын өв хариуцсан байгууллага, хүмүүс, засаг даргын тамгын газар, хөдөө аж ахуйн газар идэвхтэй оролцож, видео контент хийх, музей байгуулах, биет үзмэр зохион байгуулах зэрэг ажлуудыг санаачлан хийх боломж бололцоо бүрэн байна. Ингэснээр тариа хуралттай холбоотой соёлын өвийг хамгаалах, ач холбогдлыг нь ойлгуулах, судалгааны эргэлтэд оруулах, залуу хойч үеийнхэнд өвийн үнэ цэнийг мэдүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Ашигласан материалын жагсаалт

- Бадрал, Б. (зох), Энх-Амгалан, Б.(найр). 2005. *Сэтгэлд ургасан арвай. Баримтат кино*. Анд интертайнмэнт.
- Буянчуулган, Б. 1937. *Монголын тариалангийн түүх*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- БНСУ-ын Соёлын өвийн газар, БНСУ дахь Биет бус соёлын өвийн Ази Номхон далайн бүсийн төв. 2010. *Монгол үндэстний биет бус соёлын өв*. Ред. Уртнасан Н. Улаанбаатар.
- Гантогтох, Г., Батсүх, Ц., Алтанцэцэг, Я. ба бус. 2015. *Монгол нүүдэлчдийн тайлбар толь*. Ред. Сүлд-Эрдэнэ Г. Улаанбаатар: Адмон ХХК.
- Гонгоржав, Г. 2008. *Монголчуудын эрдэм ухааны уламжлал*. Улаанбаатар: Сутра хэвлэлийн газар.
- Гуревич, П. С. 2012. *Соёл судлал (сурах бичиг) I дэвтэр*. Орч. Алтантуяа Ц., Энхцогт Н. Улаанбаатар: “Удам соёл” ХХК.
- Мөнх-Эрдэнэ, Г., Чулуунбат, П. 2017. *Нийгэм соёлын хүн судлалын удиртгал*. Улаанбаатар: МУИС ПРЕСС.
- Марко Поло. 1987. *Орчлонгийн элдэв сонин*. Орч. Дорж Б., Идшинноров С., Очир А. Улаанбаатар.
- Роломжав, Б. 1987. *БНМАУ-ын тариалангийн хураангуй түүх. Түүхийн судлал. XX боть*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн комбинат.
- Соёлын өвийн үндэсний төвийн сан хөмрөг. *Зинаметр гуайн яриа*. DV copy II (Bet-26) 12 тоот.
- Шинжлэх Ухааны Академи. 1987. *Археологийн цуврал. IV боть*. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академи.
- Dorian Q. Fuller. 2011. Pathways to Asian Civilizations: Tracing the Origins and Spread of Rice and Rice Cultures. *Rice* 4, 78–92 (2011). <https://doi.org/10.1007/s12284-011-9078-7>
- <https://history.mn/archives/2076?fbclid=IwAR2xSkmsDO9EC9slFKyb65aVVV-jXCiptE9Muz9DBiqtoBnf-iiqlO2WYAE>.

Ярилцлага:

- С.Цолмон (Хотон, оготор элкийн)-той хийсэн ярилцлага. Увс: Тариалан сум, 2020.07.26.
- М.Хоролсүрэн (Ховог сайрын угсааны торгууд)-тэй хийсэн ярилцлага. Ховд: Булган сум, 2023.10.10.